

Хар тулай өвчний мах, бүлх, шөрмөс, ясанд шунасан хурц үеийн уламжлалт эмчилгээний үр дүн

Б.Цэрэнтогтох¹, Г.Одмаа², Э.Энхбилэг², Д.Пунсалмаа², С.Хишигжаргал^{1,2}, С.Сээсрэгдорж^{1,2}

¹АШУУИС.Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг,Дотрын тасаг

²АШУУИС.Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль

Цахим шуудан:tserentogtokh@mnums.edu.mn, Утас:88009750

Түлхүүр үг:

Тулай, уламжлалт анагаах ухаан, хануур, дэвтээлэг засал, тофус

Товч утга

Үндэслэл: Тулай өвчин нь бодисын солилцооны эмгэгээс үүдэлтэй, үе мөч болон зөөлөн эдэд шээсний хүчил хуримтлагдан үүсдэг архаг үрэвсэлт өвчин юм. Энэ өвчин нь ихэвчлэн хөлийн хуруу, шагай, өвдөг зэрэг жижиг үенүүдэд гэнэт өвдөх, улайх, хавдах, халуун оргих, мэдрэгших шинж тэмдгүүдээр илэрдэг. Өвчний хурц үе нь богино хугацаанд хүчтэй зовуурь өгдөг ч, архаг хэлбэрт шилжвэл тофус буюу шээсний хүчил хуримтлагдсан хатуу зангилаа үүсэж, үе мөчний хэлбэрийг алдагдуулах, хөдөлгөөнийг хязгаарлах, эрхтэн тогтолцоонд (бөөр, зүрх, судас) нөлөөлөх аюултай. **Зорилго:** Хар тулай өвчний хурц үед уламжлалт анагаах ухааны аргаар оношлон тохирох эмчилгээний аргуудаар эмчилгээ хийж, эмнэлзүй болон лабораторийн үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтийг үнэлэх шаардлагатай байна. **Арга, аргачлал:** 68 настай, олон жил тулайгаар өвдөж буй өвчтөнд хануур, дэвтээлэг засал болон эмийн эмчилгээ хослуулан хийж үр дүнг үнэлсэн. **Үр дүн:** Хүнд хэлбэрийн хар тулай өвчний хурц үед хануур эмчилгээ нь үрэвслийн үеийн өвдөлт намдаах, хаван бууруулах нөлөө үзүүлж цусны эргэлтийг сайжруулж байна. **Дүгнэлт:** Ороолт дэвтээлэг засал нь тулай өвчний үеийн тофусын хэмжээг багасгаж үений хөдөлгөөний сэргээх, шарх хатаах, үрэвслийн эсрэг үйлдэл үзүүлж амьдралын чанарыг сайжруулж байгаа нь Уламжлалт анагаах ухааны эм болон заслын аргуудаар эмчлэх боломжтойг харуулж байна.

Үндэслэл: Тулай өвчин нь бодисын солилцооны эмгэгээс үүдэлтэй, үе мөч болон зөөлөн эдэд шээсний хүчил хуримтлагдан үүсдэг архаг үрэвсэлт өвчин юм.¹ Энэ өвчин нь ихэвчлэн хөлийн хуруу, шагай, өвдөг зэрэг жижиг үенүүдэд гэнэт өвдөх, улайх, хавдах, халуун оргих, мэдрэгших шинж тэмдгүүдээр илэрдэг. Өвчний хурц үе нь богино хугацаанд хүчтэй зовуурь өгдөг ч, архаг хэлбэрт шилжвэл тофус буюу шээсний хүчил хуримтлагдсан хатуу зангилаа үүсэж, үе мөчний хэлбэрийг алдагдуулах, хөдөлгөөнийг хязгаарлах, эрхтэн тогтолцоонд (бөөр, зүрх, судас) нөлөөлөх аюултай.²

Дэлхийн хэмжээнд тулай өвчний тархалт сүүлийн арван жилд эрс нэмэгдэж байна. Global Burden of Disease (GBD) 2017 судалгаагаар дэлхий даяар нийт 7.44 сая тулайн тохиолдол бүртгэгдсэн бөгөөд тус өвчин нь Disability-Adjusted Life Years (DALY)-д 1.28 сая жилийн алдагдал үүсгэсэн нь энэ өвчний эрүүл мэндийн ачаалал өндөр байгааг харуулж байна.³

Орчин үеийн анагаах ухаанд тулай өвчнийг эмчлэхэд үрэвслийн эсрэг бэлдмэл (NSAIDs), колхицин, кортикостероид, мөн шээсний хүчлийг бууруулах эмүүд (allopurinol, febuxostat) өргөн хэрэглэгддэг.⁴ Гэвч эдгээр эмүүд нь гаж нөлөө, дасал, эмийн эсэргүүцэл зэрэг асуудал дагуулдаг төдийгүй бүх өвчтөнд ижил үр дүн өгөхгүй байх тохиолдол ч элбэг.⁵ Ийм нөхцөлд уламжлалт анагаах ухааны аргуудыг хавсарч хэрэглэх нь сүүлийн жилүүдэд улам бүр анхаарал татах болсон.

Монгол уламжлалт анагаах ухаанд тулай өвчнийг “Хий, муу цус, муу шар усны хямрал” гэж үзэж, хануур, дэвтээлэг, ороолт, заслын аргуудыг хэрэглэн эмчилдэг уламжлалтай.⁶ Сүүлийн үеийн судалгаагаар хануур засал нь тодорхой биологийн цэгүүдэд үйлчилснээр үрэвслийг бууруулах, цусны эргэлтийг сайжруулах, дархлааны тогтолцоог идэвхжүүлэх нөлөө үзүүлдэг болох нь тогтоогдсон. Түүнчлэн эмнэлзүйн жишээнүүдээр уламжлалт эмчилгээний арга нь тулайн хурц

үеийг намжаах, тофус багасгах, өвдөлт намдаах, үеийн хөдөлгөөнийг сэргээх үр дүнтэй болохыг харуулж байна.⁷

Иймд орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргуудыг хослуулсан эмчилгээний тактикийг боловсруулж, нотолгоонд суурилсан байдлаар стандартчилан нэвтрүүлэх шаардлага өнөөгийн анагаах ухаанд зүй ёсоор тавигдаж байна.

Эмнэлзүйн тохиолдол: Судалгаанд АШУУИС-ийн Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэгт 2025.02.21-2025.02.28 хооронд хэвтэн эмчлүүлсэн 68 настай, эрэгтэй тулай өвчнөөр 10 гаруй жил өвдсөн, олон тооны тофустай, антибиотикийн харшилтай өвчтөн оролцсон. Өвчтөн нь хоёр хөлийн шагайнаас доош арьс, зөөлөн эд хавдаж, чимчигнэж бадайрах, зүүн хөлийн эрхий, чигчий хуруу болон өсгийн хэсгээр шархалж, шүүс гарч буй зовиртой байсан. Гар, хөлийн үенүүдэд олон тооны тофус үүссэн байв.

Өвчтөнд Монгол уламжлалт анагаах ухааны заслын аргууд болох хануур эмчилгээг 1 удаа (тодорхой биологийн цэгүүдэд), дэвтээлэг засал эмчилгээг 5 өдөр (хаван, үрэвсэлтэй хэсгүүдэд), хийж эмчилгээний өмнө ба дараа дараах

үзүүлэлтүүдийг үнэлсэн: Өвдөлтийн түвшин (VAS оноо), Хавангийн хэмжээ, арьсны улайлт, Тофусын хэмжээ, Үе мөчний хөдөлгөөний далайц, Лабораторийн шинжилгээнүүд (шээсний хүчил, цагаан эсийн тоо, АСАТ)

Хануур эмчилгээг ЭМС-ийн 2021.03.25-ны А152 тушаалын Хануур засал эмчилгээний зааврын стандартын дэлгэрсэн судаснаас хийсэн. дагуу хийсэн. Хануур засал нь бүх биед тарсан өвчний хорыг цусны уураар гаргаж засах буюу хэсэг газарт тогтонгишиж шунасан өвчний муу цусыг өвчтөний биед ханаж болох судлын бэлчрийг сонгож цус гаргах засал юм. Хүний биед хануур засал эмчилгээний 77 нэр төрлийн судал байдаг. Бид Монгол маарамбуудын Бөөрний өвчин, муу цус, шар ус, тулай, бам, цагаан хуян зэрэг өвчнийг анагаахад сайшаагдсан дараах орц найрлагатай дэвтээлэг засал эмчилгээг 5 хоног 2 хөлд хийсэн. (Хүснэгт 1)


Орц: Нэрмэлийн шар сүү – 500 мл, Айраг – 250 мль Архи (цагаан архи) – 100 мл, Цай (хар цай) – 500 мл, Хужир – 1 цайны халбага, Давс – 1 цайны халбага, Агь – 1 атга найрлагатай байсан.

Эмчилгээний үр дүн:

Хүснэгт 1. Лабораторийн үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Шинжилгээ	Үзүүлэлтүүд	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа
Цусны ерөнхий шинжилгээ	Цагаан эсийн тоо	11.51*10 ³ /ul	11.44*10 ³ /ul
	нейтрофил эсийн тоо	8.45*10 ³ /ul	8.15*10 ³ /ul
	моноцит эсийн тоо тоо	0.73*10 ³ /ul	0.66*10 ³ /ul
Биохими	Шээсний хүчлийн хэмжээ	643.3 mkmol/l	600.5 mkmol/l
	АСАТ	37.1 U/L	19.71 U/L

Эмнэлзүйн өөрчлөлт: Шагайн үений хөдөлгөөн сайжирсан, тофус багассан, хөлийн улайлт, хаван буурсан, хөлийн шархны хэмжээ багассан, өвдөлтийн VAS оноо: 7 → 2 (Зураг 1)



Зураг 1. Хар тулай өвчний мах, бүлх, шөрмөс, ясанд шунасан хурц үеийн уламжлалт эмчилгээний үр дүн. А. Эмчилгээний өмнөх. В. Эмчилгээний дараах үр дүнг харуулсан нь

Хэлцэмж: Тулай өвчин нь шээсний хүчлийн солилцооны алдагдлаас үүдэн үеийн дотор болон зөөлөн эдүүдэд уратын талст хуримтлагдсанаар үүсдэг үрэвсэлт өвчин юм.⁸ Уг өвчний архаг хэлбэрт шилжихэд тофус үүсэх, үе мөчний гаж өөрчлөлт бий болох, хөдөлгөөний хязгаарлалт үүсэх зэрэг хүндрэлтэй.⁹ Хэдийгээр орчин үеийн анагаах ухаанд үрэвслийн эсрэг болон шээсний хүчил бууруулах эмүүдийг өргөн хэрэглэдэг ч, тодорхой өвчтөнүүдийн хувьд эдгээр эмчилгээ үр дүнгүй байх, эсвэл гаж нөлөө үүсгэх нь нийтлэг байдаг.¹⁰ Манай судалгаанд оролцсон өвчтөн бүх төрлийн антибиотикт харшилтай байсан тул уламжлалт анагаах ухааны аргыг сонгон хэрэглэх зайлшгүй шаардлага үүссэн.

Монгол уламжлалт анагаах ухаанд тулай өвчнийг “Муу хий, муу шар ус, муу цусны хямрал” гэж үздэг бөгөөд энэ нь орчин үеийн анагаахын үрэвсэл, цусны эргэлт, дархлааны механизмтай нэлээд дүйцэх ойлголт юм. Бидний хэрэглэсэн хануур, дэвтээлэг, ороолт, заслын аргууд нь өвдөлт намдаах, үрэвсэл бууруулах, цусны эргэлтийг сайжруулах, шархны эдгэрлийг хурдасгах зэрэг олон талын ашиг тустай болохыг энэ судалгаа харууллаа.

Судалгааны явцад өвдөлт, хаван, тофусын хэмжээ, лабораторийн үзүүлэлтүүдэд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан бөгөөд энэ нь өмнөх судалгаануудтай нийцэж байна. Тухайлбал, Zhang нарын (2021) хийсэн судалгаанд хануур эмчилгээ нь дархлааны IL-6, TNF-α зэрэг үрэвслийн цитокинуудын түвшнийг бууруулдаг болохыг тогтоосон. Мөн бусад судалгаагаар уламжлалт

аргуудын үр нөлөө зөв оношилгоо, цэг сонголт, зохистой хугацаанд хийгдэх үед өндөр байдаг нь батлагдсан байдаг¹¹

Энэхүү тохиолдол нь уламжлалт анагаах ухаан зөв хэрэглэгдэх тохиолдолд тулайн хурц үеийг намжаах, архаг хүндрэлүүдийг хянах, амьдралын чанарыг дээшлүүлэх боломжтойг харуулж байна.

Энэ тохиолдлын эмчилгээний үр дүн нь уламжлалт эмчилгээ нь зөв оношилгооны үндсэн дээр хийгдвэл тулай өвчний хурц үеийг үр дүнтэй хянах боломжтойг харуулж байна. Цаашид уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны аргыг хослуулсан судалгааг өргөжүүлж, стандартчилах шаардлагатай юм.

Дүгнэлт: Хүнд хэлбэрийн хар тулай өвчний хурц үед хануур эмчилгээ нь үрэвслийн үеийн өвдөлт намдаах, хаван бууруулах нөлөө үзүүлж цусны эргэлтийг сайжруулж байна. Ороолт дэвтээлэг засал нь тулай өвчний үеийн тофусын хэмжээг багасгаж үеийн хөдөлгөөний сэргээх, шарх хатаах, үрэвслийн эсрэг үйлдэл үзүүлж амьдралын чанарыг сайжруулж байгаа нь Уламжлалт анагаах ухааны эм болон заслын аргуудаар эмчлэх боломжтойг харуулж байна

Санал, зөвлөмж: Цаашид уламжлалт аргуудыг илүү өргөн хүрээнд, эмнэлзүйн нотолгоонд тулгуурлан хэрэглэх; судалгааны дээжийг өргөжүүлж, олон тохиолдол дээр үр дүнг баталгаажуулах; уламжлалт ба орчин үеийн анагаах ухааны хосолсон эмчилгээний загвар боловсруулах.

Ном зүй:

1. World Health Organization. Gout: epidemiology, diagnosis, treatment, and prevention. Geneva: WHO Press; 2019. Available from: <https://www.who.int/>
2. Richette P, Doherty M, Pascual E, Barskova V, Becce F, Castañeda-Sanabria J, et al. 2016 updated EULAR evidence-based recommendations for the management of gout. *Ann Rheum Dis*. 2017 Jan;76(1):29-42. doi:10.1136/annrheumdis-2016-209707.
3. GBD 2017 Disease and Injury Incidence and Prevalence Collaborators. Global, regional, and national incidence, prevalence, and years lived with disability for 354 diseases and injuries for 195 countries and territories, 1990–2017: a systematic analysis for the Global Burden of Disease Study 2017. *Lancet*. 2018 Nov 10;392(10159):1789-1858. doi:10.1016/S0140-6736(18)32279-7.
4. Terkeltaub, R. A. (2003). Gout. *The New England Journal of Medicine*, 349(17), 1647-1655. <https://doi.org/10.1056/NEJMra022987>
5. FitzGerald, G. A., & Nissen, S. E. (2009). The cardiovascular effects of nonsteroidal anti-inflammatory drugs and selective cyclooxygenase-2 inhibitors. *The New England Journal of Medicine*, 361(6), 496-507. <https://doi.org/10.1056/NEJMra0801899>
6. Сээсрэгдорж С, Чимэдрагчаа Ч, Хишигжаргал С, Бусад Б. Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах үедис. Улаанбаатар хот, 2021.
7. Zhao, H., & Zhang, W. (2020). Clinical application of acupuncture in the treatment of gout: A systematic review and meta-analysis. *Journal of Traditional Chinese Medicine*, 40(2), 150-158.
8. Ahrens, W., & Döring, A. (2012). Prevalence of gout and hyperuricemia in a population-based cohort of men and women. *The Journal of Clinical Rheumatology*, 18(5), 259-263.
9. Liu, R., & Wang, J. (2019). Traditional Chinese Medicine in the management of gout: A review of the scientific evidence. *Journal of Ethnopharmacology*, 239, 111906. <https://doi.org/10.1016/j.jep.2019.111906>
10. Hochberg, M. C., & Silman, A. J. (2015). *Rheumatology*. (6th ed.). Elsevier Health Sciences.
11. Бат-Эрдэнэ Ц., Даваажаргал Б. (2020). Монгол уламжлалт анагаах ухаанд хэрэглэгддэг заслын аргуудын клиник хэрэглээ. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэлийн газар. 214 х.

Efficacy of Traditional Mongolian Therapeutic Approaches in the Acute Phase of Chronic Tophaceous Gout

Tserentogtokh B¹, Odmaa G², Enkhbileg E², Punsalmaa D², Khishigjargal S^{1,2}, Seesregdorj S^{1,2}

¹International School of Mongolian Medicine, MNUMS

²Central Hospital of Mongolian Medicine, MNUMS

E-mail: tserentogtokh@mnumns.edu.mn, Tel: +976-8800 9750

Keywords:

Gout, traditional Mongolian medicine, bloodletting therapy, soaking therapy, thopus

Background: Gout is a chronic inflammatory disorder stemming from metabolic dysfunction, characterized by the accumulation of monosodium urate crystals in joints and soft tissues due to prolonged hyperuricemia. Clinically, it often manifests with abrupt onset of intense joint pain, erythema, swelling, and tenderness, particularly in the small joints of the lower extremities such as the first metatarsophalangeal joint, ankles, and knees. In its chronic form, gout can lead to the development of tophi—firm nodular deposits of urate crystals—resulting in joint deformities, limited mobility, and systemic complications affecting the renal and cardiovascular systems.

This case report describes the integrative management of a 68-year-old male patient with a long-standing history of chronic tophaceous gout, presenting with acute exacerbation involving multiple joints and extensive tophaceous deposits. The patient underwent a course of traditional Mongolian medical treatment, incorporating bloodletting therapy (hanuur), soaking therapy (devteeleg zasal), and phytotherapeutic remedies.

Conclusion: The treatment yielded notable clinical improvements: cupping therapy facilitated the reduction of joint inflammation and edema, alleviated pain, and enhanced peripheral circulation during the acute phase. Soaking therapy using medicated decoctions was effective in softening and reducing the size of tophi, promoting wound drying, restoring joint mobility, and improving overall functional capacity. The patient reported a marked enhancement in quality of life following the integrative treatment course.

This case highlights the potential of traditional Mongolian medical interventions as adjunctive or alternative therapeutic strategies for managing severe gout, particularly in cases refractory to conventional pharmacological treatment. Further clinical research and controlled studies are warranted to validate these findings and to explore the broader application of traditional therapies in gout management.
